

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/04

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.IV	2022.IV	2023.III	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	-	-	13.6	-	-	-	7.9% ▲
Инфляц	хувь	11.3%	14.4%	12.2%	1.3% ▲	-	4.8% ▲	-3.1 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	-	8.5% 2022 оны У1	6.6% 2023 оны У1	-	1.3% ▲ нэгж хувиар	-	-1.9% нэгж хувиар ▼
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1099.6	-292.3	656.6	442.9 ▲	-	-	1391.9 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3496.41	3041.90	3524.98	-28.57 ▼	-	-	454.51 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	2423.4	450.0	1824.4	599.0 ▲	-	-	1973.4 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	19.6	3.8	5.5	-10% ▼	-	-	5 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	483.3	469.3	120.4	-17% ▼	-	-	3% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь			13%	0%	-	0%	7% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.69	3.31	3.43	7% ▲	-	-	11% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	9.66%	9.38%	9.58%	0.07 нэгж хувиар ▲	-	-	0.27 нэгж хувиар ▲

ОНЦЛОХ СТАТИСТИК:

2023 ОНЫ 1-Р УЛИРАЛД ДНБ 7.9 ХУВИАР ӨСЛӨӨ	ДНБ хэмжээ оны үнээр 13.6 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 5.6 их наяд төгрөг болж Монгол Улсын эдийн засаг эхний улирлын байдлаар 7.9 хувийн өсөлтийг үзүүлэв. Үүнд Тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар 76.3 хувь, Уул уурхай, олборлолтын салбар 49.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Харин Боловсруулах үйлдвэрлэлийн салбар -6.7 хувь, Хөдөө аж ахуйн салбар -5.1 хувиар тус тус буурав.
НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ 5 ДАХИН ӨСӨВ	2022 оны эхний 4 сарын байдлаар 3.8 сая тн нүүрс экспортлож байсан бол энэ оны эхний 4 сард нийт 19.6 сая тн нүүрс экспортлож 5 дахин өсөж 3.1 тэрбум ам.долларын орлого оруулжээ. Энэ нь түүхэн дээд үзүүлэлт болж байна.


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
1. Гэрэгэ бондын төлбөрийг бүрэн төлж барагдууллаа	2023/05/01	Монгол Улсын Засгийн газраас анх 2017 онд авч байсан 800 сая ам.долларын “Гэрэгэ” бондын үлдэгдэл болох 387 сая ам.долларыг төлснөөр, уг бондын төлбөр бүрэн барагдаж дууслаа.
2. Бүх хүүхдэд мөнгө олгох асуудлыг эргэн харна	2023/04/06	Бүх хүүхдэд мөнгийг олгох санхүүгийн эх үүсвэрийг 6,7 сард шийдэх боломж бүрдэж эхэлнэ. Гэхдээ ОУ-ын байгууллагуудтай ярилцаж хийхгүй бол төсөв хэтэрхий зардлаа тэлээд байна гэдэг шүүмжлэлд ордог.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Инфляц



Нөлөөлөл


2023 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өсөв. Харин өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 3.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 4 дугаар сард 3496.41 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 454.51 төгрөгөөр чангарсан бол, өмнөх сараас 28.57 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 7%-иар өсч, 3.69 тэрбум ам.долларт хүрээд байна.

Улсын төсөв



Тэнцвэржүүлсэн тэнцэл эхний 4 сард 1.1 их наяд төгрөгийн ашигтай гарчээ. Татварын нийт орлогод 2023 оны эхний 4 сарын байдлаар орлогын албан татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар, бусад татвар, төлбөр, хураамжийн орлогынх 2.5 нэгж хувиар тус тус өсөж, харин онцгой албан татварын орлогынх 3.4 нэгж хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварын 3.1 нэгж хувиар, нийгмийн даатгалын орлогынх 1.5 нэгж хувиар, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.8 нэгж хувиар тус тус буурсан байна.

Гадаад худалдаа



Гадаад худалдааны тэнцэл 2023 оны эхний 4 сард 2.4 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.0 (5.4 дахин) тэрбум америк доллароор өсжээ. Харин 2023 оны 4 дүгээр сард 597.7 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 178.5 (23.0%) сая америк доллароор буурсан байна. БНХАУ-тай 2023 оны эхний 4 сард 5.7 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 74.2 хувийг эзэлж байна.

Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.
Эх сурвалж: Олон улсын валютын сан
- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа
Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2023 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn